



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 06 сарын 13 өдөр

Дугаар А/279

Чингис хот

Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт  
шилжүүлсэн хугацааг сунгасантай холбогдуулан  
авах зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4, 11 дүгээр зүйлийн 11.3.2, 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 118, 154 дүгээр тогтоол, Улсын Онцгой комиссын даргын 2021 оны 41, 43, 46 дугаар тушаал, Аймгийн Онцгой комиссын 18 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахалтай тэмцэх, эрсдэлийг бууруулах зорилгоор Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг 2021 оны 6 дугаар сарын 11-ний өдрөөс 2021 оны 6 дугаар сарын 30-ны өдрийг хүртэл сунгасугай.

2. Өндөржүүлсэн бэлэн байдлын зэргийг сунгасантай холбогдуулан дээрх хугацаанд бүх төрлийн хуулийн этгээдийн цагийн хуваарь, сумын орох гарах хөдөлгөөнийг хязгаарлах зэрэг арга хэмжээг үүссэн нөхцөл байдалд үндэслэн сумын онцгой комиссын хуралдаанаар тухай бүр шийдвэр гаргаж ажиллахыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Аймгийн хэмжээнд жагсаал цуглаан, хурал зөвлөгөөн, соёл урлаг, спортын арга хэмжээ болон олон нийтийг хамарсан үйл ажиллагаа зохион байгуулах, спорт заал, баар, караоке, компьютер болон биллиард тоглоомын газар, сүм хийдийн үйл ажиллагааг 2021 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 06:00 хүртэл хязгаарласугай

4. Өндөржүүлсэн бэлэн байдлын хугацааг сунгасантай холбогдуулан халдвар хамгааллын дэглэмийг сахиулж эм, эмийн хэрэгслийн нөөцийг бүрдүүлж, халдвар авсан иргэдийг эмчлэх арга хэмжээг зохион байгуулж ажиллахыг Эрүүл мэндийн газар (Л.Мэндбаяр), сумдын Эрүүл мэндийн төв, сумд, тосгодын Засаг дарга нарт тус тус даалгасугай.

231010492

5. Халдварын тархалтаас урьдчилан сэргийлж тандалт судалгааг шуурхай зохион байгуулж, сэжигтэй тохиолдол, хавьтал бичий иргэдээс шинжилгээ авч халдварын голомтын цар хүрээг тогтоож, хариу арга хэмжээг авч ажиллахыг Эрүүл мэндийн газар (Л.Мэндбаяр), нийтийн эзэмшлийн зам талбай болон голомтын эцсийн

халдваргүйтгэл хийлгэх арга хэмжээг зохион байгуулахыг аж ахуйн нэгж байгууллагын удирдлагууд, Зооноз өвчин судлалын төв (Ц.Гэрэлмаа), сумдын Засаг дарга нарт, хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн хяналтын газар (Б.Сүнгээ)-д тус тус даалгасугай.


6. Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахалтай холбоотой мэдээллийг өдөр бүр тогтмол цагт иргэдэд цахимаар хүргэж ажиллахыг шуурхай штаб (хурандаа Ж.Эрдэнэбат), Эрүүл мэндийн газар (Л.Мэндбаяр), Мэргэжлийн хяналтын газар (Б.Сүнгээ)-т тус тус даалгасугай.

7. Голомтод бүс нутгаас аймаг сумд руу зорчих иргэн тээврийн хэрэгслийн хяналтыг сайжруулж, вакцинжуулалтын бүрэн тунд хамрагдсанаас хойш 14 хоног өнгөрснөөс бусад иргэдийг Улсын Онцгой комиссын даргын 2021 оны 43 дугаар тушаалын 2 дугаар хавсралт "Гэр, ажиглалтын үйл ажиллагааг зохицуулах түр журам"-ын 2.2.4-т "Халдвар бүртгэгдсэн бүс нутгаас зорчиж буй иргэнийг гэрийн тусгаарлалтад 7 хоног" гэсэн заалтыг хэрэгжүүлж, энэ ажлыг зохион байгуулахад Төрийн байгууллагуудад хариуцуулж ажиллахыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

8. Дамжин өнгөрөх тээврийн хэрэгслийг зогсоохгүйгээр өнгөрүүлэхээр зохицуулж хяналт тавьж ажиллахыг Цагдаагийн газар (хурандаа Б.Батсайхан)-т үүрэг болгосугай.

9. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Ц.Чогсомжав), Шуурхай штабын дарга (хурандаа Ж.Эрдэнэбат) нарт тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ